

БАТЛАВ



“ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН
НИСЭХ БУУДЛЫН ЗАХИРАЛ

Д.МӨНХБААТАР

“САЙХАН ТӨМӨР” ХХК – ИЙН
ЗАХИРАЛ

А.ТОГМИД

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № ХА/04-18

2018.01.18

Улаанбаатар хот

Нэг талаас “Чингис хаан” Олон улсын нисэх буудал (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Сайхан төмөрт” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 01 дугаар сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Чингис хаан” ОУНБ-ын халуун, хүйтэн ус, галын ерөнхий шугамыг солиход шаардлагатай материалыг хавсралт №1-д заагдсан нэр төрөл, тоо ширхэг, үнийн дагуу нийлүүлнэ.
3. Гэрээний нийт дүн : 27,071,400 / хорин долоон сая далан нэгэн мянга дөрвөн зуу / төгрөг / **НӨАТ багтсан** /. Санхүүжилтийн эх үүсвэр нь “Чингис хаан” ОУНБ-ын өөрийн хөрөнгөөр.
4. Нийлүүлэгч нь “Чингис хаан” ОУНБ-ын халуун, хүйтэн ус, галын ерөнхий шугамыг солиход шаардлагатай материалыг 2018 оны 01 сарын 18-ны өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн дотор барааг нийлүүлнэ.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 5.1 Гэрээний тусгай нөхцөл
 - 5.2 Гэрээний ерөнхий нөхцөл
 - 5.3 Хавсралт
 - 5.4 Бараа нийлүүлсэн санхүүгийн баримт


Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, нийлүүлэгч нь энэ гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх үүрэг хүлээнэ.
7. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу бараа нийлүүлсэн акт, зарлагын падаан, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.
9. Захиалагч барааг зөрчил гологдолтой гэж үзэх, зорчигч үйлчлүүлэгчдээс гомдол гаргах, хэрэглээний явцад чанарын шаардлага хангахгүй тохиолдолд барааг өөр бараагаар сольж өгөх үүрэгтэй.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

Захиалагчийг төлөөлж:

Ерөнхий инженер



С.Хайыпхан

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн
хэлтсийн дарга



Ц.Эрдэнэчимэг

Аж ахуй, хангамжийн
тасгийн дарга



Ц.Жавхлантөгс

Нийлүүлэгчийг төлөөлж:

“Сайхан Төмөрт” ХХК-ийн захирал



А.Тогмид

Талуудын албан ёсны хаяг

Захиалагч:

ХУД, 10-р хороо, Буянт-Ухаа дахь
“Чингис хаан” ОУНБ

Утас: 283021, 283019
Факс: 70049617

Нийлүүлэгч:

ХУД, 2-р хороо, 19-р хороолол,
21-55 тоот

Утас: 99057196

Харилцах данс

Захиалагч:

Голомт банк: 1301041321
Худалдаа хөгжлийн банк: 451004193

Нийлүүлэгч:

Голомт банк: 1410001827

ГИС ХААН
НИСЭХ
ХЯ
УУЛИЙН М